



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 796

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10, 5.1 дэх заалт, Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14/03 дугаар тогтоол, Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны А/52 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс, Ховд аймгийн өмчөөс шилжүүлсэн 2 нэрийн, нийт 40,780,000.00 (дөчин сая долоон зуун наян мянган) төгрөгийн балансын үнэ, 39,313,334.00 (гучин есөн сая гурван зуун арван гурван мянга гурван зуун гучин дөрөв) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн ангид эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, хавсралтад заасан Хилийн цэргийн ангийн захирагч, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Цогтсайхан, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

123006879

37-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
794 дугаар тогтоолын хавсралт



ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА ХИЛИЙН АНГИ, САЛБАРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгө эзэмшигч төрийн өмчит байгууллага	Хөрөнгийн нэр, марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Ховд аймгийн Алтай сумын Ерөнхий боловсролын сургууль	НРЖ маркийн Нам даралтын халаалтын зуух	1/1/2017	8,500,000.00	7,033,334.00	1,466,666.00	Хилийн цэргийн 0130 дугаар анги
2	Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг	Уаз-2206 15-10 УВХ Фургон автомашин	1/1/2013	32,280,000.00	32,280,000.00	-	Хилийн цэргийн 0245 дугаар анги
Нийт дүн				40,780,000.00	39,313,334.00	1,466,666.00	